

**НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН
7 ДУГААР САРЫН ТАЙЛАН**

2022.07.29

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчийн харилцааны газарт 7 дугаар сард иргэд, аж ахуй нэгж байгууллага болон албан хаагчдаас нийт 2 өргөдөл, гомдол ирснийг хүлээн авч “Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль”-ийн дагуу шийдвэрлэн ажиллалаа.

Өргөдөл гомдол бүртгэгдсэн хэлбэр:

Ангилал	Нийт	Шийдвэрлэлт			Шийдвэрлэлтийн хувь
		Шийдвэр лэсэн	Судалж байгаа	Хугацаа хэтэрсэн	
ННЗБ бүртгэсэн	1	1	-	-	100%
11-11 төв	1	1	-	-	100%
Бүгд	2	2	0	0	100%

Өргөдөл, гомдлыг хэлтэс нэгжээр ангилбал

Д/Д	Хэлтэс	Нийт	Шийдвэрлэлт			Шийдвэр лэлтийн хувь
			Шийдвэр лэсэн	Судалж байгаа	Хугацаа хэтэрсэн	
1	Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс	1	1	-	-	100%
2	Өмчийн менежментийн хэлтэс	1	1	-	-	100%
Нийт		2	2	0	0	100%

Өргөдөл, гомдлын хандалт

Д/Д	Ангилал	Тоо
1	Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудын үйл ажиллагааны тухай	1
5	Байр хувьчлалын асуудлаар	1

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хугацаа

Д/Д	Өргөдлийн тоо	Хоног	Цаг	Минут
	2	8	0	28

Өргөдөл, гомдлын хариу өгсөн хэлбэр

Д/Д	Хариу өгсөн хэлбэр	2022 он
1	Програм хангамж + Мессеж + Албан бичгээр хариу өгсөн	1
2	Програм хангамж + Мессеж + Утсаар хариу өгсөн	1

Өргөдөл, гомдол шийдвэрлэсэн байдал

Д/Д	Ангилал	Тоо
1	Иргэний талд шийдвэрлэсэн өргөдөл	1
2	Боломжгүй тухай хариу өгсөн өргөдөл <ul style="list-style-type: none">Байгууллагын чиг үүрэгт хамааралгүй өргөдөл	1

Өргөдөл, гомдлын төрөл

Д/Д	Төрөл	2022 он
1	Хүсэлт	1
2	Гомдол	1

Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд 1 гомдол бүртгэгдсэн.

Д/Д	Өргөдлийн дугаар	Өргөдлийн агуулга	Шийдвэрлэлт	Тайлбар
1	G220704131 гомдол	Нийслэлийн Төр Захиргааны авто баазын ажилчдын байрны газрыг хувьчилж өгөх боломж байна уу ? Яагаад хувьчилж өгөхгүй байгаа талаар мэдээлэл авмаар байна. Энэ асуудлыг холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлэж өгнө үү.	2022.07.19-ны өдөр Иргэн О.Гарамгайбаатартай 89002064 дугаарын утсаар холбогдож асуудлыг нь тодруулж хариу өгсөн. Иргэн нь Засгийн газрын авто баазын ажилчдын хувьчилсан байрны талаар мэдээлэл авахыг хүссэн бөгөөд тус газарт өргөдөл нь ирсэн тул буцаав.	Чиг үүргийн бус

Тус гомдол нь 2022.07.04-ний өдөр Засгийн газрын 11-11 төвд бүртгэгдсэн бөгөөд иргэний гомдол нь байрны хувьчлалын асуудлаар мэдээлэл авахыг хүссэн. Гэвч тухайн асуудал манай байгууллагын чиг үүрэгт хамааралгүй байна. Учир нь Орон сууцны хувьчлалын асуудлыг Орон сууц хувьчлах тухай хуульд заасны дагуу Төрийн Өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны “Журам батлах тухай” 67 дугаар тогтоолоор Орон сууц хувьчлалын товчоогоор дамжуулан шийдвэрлүүлэхээр заасан байдаг.

11-11 төвд бүртгэгдсэн ихэнх гомдол нь манай байгууллагын чиг үүрэгт хамааралгүй асуудлаар хандаж гаргасан байдаг. Иймд иргэний өргөдөл, гомдлыг бүртгэж байгаа ажилтан байгууллагуудын чиг үүргийг маш мэддэг байх шаардлагатай байна. Үүнээс болж иргэн цаг хугацаа алдах, хүссэн хариултаа авч чадахгүй байх асуудал үүсч байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

- Өргөдөл, гомдлын мэдээг 14 хоног тутам гаргаж удирдлагад танилцуулан мэдээллийн самбарт байршуулж байна.
- Өргөдөл, гомдлын мэдээг олон нийтэд ил тод байлгах хүрээнд байгууллагын цахим сайтад байршуулсан. Цаашид сар бүр мэдээллийг байршуулна.
- Энэ сард өргөдөл гомдлын зөрчил гараагүй. Албан хаагчид баримт нотолгоо, нэмэлт мэдээлэл шаардлагагүй өөрийн ажил үүргийн хүрээнд шийдвэрлэх боломжтой өргөдлийг ажлын 3 хоногт багтаан шийдвэрлэж байгаа бөгөөд хугацаа шаардлагатай тохиолдолд 10 хоног тутамд шийдвэрлэлтийн явцын тэмдэглэл хөтөлж хэвшиж байна.
- Энэ сарын өргөдөл гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаанд наадмын амралтын өдрүүд нөлөөлсөн учир хугацаа харьцангуй өндөр гарсан байна.
- Иргэдээс өргөдөл гомдол шийдвэрлэлтэнд хангалтгүй буюу байгууллагад хандаж гаргасан гомдол, санал ирээгүй.